



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/378

Мандалговь

Хүн ам, орон сууцны тооллогын гэрээт
ажилтан ажиллуулах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.3 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318-р тушаалын 318.2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах, Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, сайжруулалтыг хийж гүйцэтгэх зорилгоор аймгийн тооллогын түр товчоонд 2019 оны 10 сарын 01- ээс 2019 оны 12-р сарын 31 хүртэл ажиллах гэрээт ажилтны ажиллах нөхцөл, цалингийн зардлын дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Гэрээт ажилтны цалин, компьютер, тоног төхөөрөмжийн зардалд 2,025,000 (Хоёр сая хорин таван мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191073